



МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Г

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4, 76 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 76 дугаар зүйлийн 2, 89 дүгээр зүйлийн 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 18 дугаар зүйлийн 1, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 9 дэх заалтыг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. “Төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилох үлгэрчилсэн журам”-ыг нэгдүгээр, “Төрийн өмчит компани, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах, ажилд томилох, ажлаас чөлөөлөх журам”-ыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. “Төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилох үлгэрчилсэн журам”-ыг үндэслэн төрийн өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагаа, ажлын онцлогийг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилох журмыг боловсруулан баталж, мөрдөн ажиллахыг тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд зөвлөсүгэй.

3. “Төрийн өмчит компани, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах, ажилд томилох, ажлаас чөлөөлөх журам”-ыг 2010 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газар /Х.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СУГАР

Л.ГАНБАТ

Л.ГАНБАТ

10/52

Төрийн өмчийн хорооны 2010 оны 3.
дугаар сарын 15.ны өдрийн 12 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛЖ, ТОМИЛОХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ**

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмыг төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх, томилохтой холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад зөвлөмж, чиглэл болгоно.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах зорилго нь компанийн эрх ашгийн төлөө ажиллах чадвартай, холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан иргэнийг шилж сонгоход оршино.

1.3. Энэхүү журам нь төрийн өмчийн оролцоотой компанид хамаарна.

1.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга ёс, ил тод, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

1.5. Хувь нийлүүлэгчдийн хурал нь зөвхөн энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалттай орж сонгогдсон хүний асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргана. Энэ шийдвэр нь эцсийнх болно.

1.6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулахад энэ журам хамаарахгүй.

1.7. Сонгон шалгаруулалттай холбогдон гарах зардлыг тухайн компани хариуцна.

**ХОЁР: ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн” гэж өөрөө, эсхүл эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, дүү болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн компанийд, эсхүл түүний хараат болон охин компанийн эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй хүнийг хэлнэ.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь төрөөс хараат бусаар зөвхөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого явуулах үүрэгтэй.

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийг $\frac{1}{4}$ хувь нь хараат бус гишүүн байна.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн /цаашид “нэр дэвшигч” гэх/ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

а/ Санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн мэргэжилтэй эсхүл тухайн салбараар мэргэшсэн байх;

б/ Сүүлийн 3 жил тухайн компанийн толгой болон хараат, охин компанийн эрх бүхий албан тушаал болон зөвлөх, хүний нөөц, шагнал урамшуулал хариуцсан ажилтанаар ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй, мөн өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ холбоогүй байх;

в/ Тухайн компанийн толгой болон хараат, охин компанийтай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын /зээлдүүлэгч, хувь нийлүүлэгчид, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран ажиллагсад г.м / ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа холбоогүй байх;

г/ Тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд, төрөл, садангийн холбоогүй байх;

д/ Компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх; /нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дун нь компанийн нийт активийн 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/

е/ Нэр дэвшигч өөрөө эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд бие дааж нэр дэвшүүлэх эрх олгохуйц хувьцааны багцыг эзэмшдэггүй байх;

2.5. Нэр дэвшигчийг доорхи нөхцөлд сонгон шалгаруулалтад оруулахгүй. Үүнд:

а/ Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн;

б/ Төрийн албан хаагч буюу тухайн салбарын төрийн өмчийн оролцоотой, эсхүл хувийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

ГУРАВ: СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАХ

3.1. Тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дэх Томилгооны дэд хороо сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доoshгүй хоногийн өмнө төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай зар мэдээг өдөр тутмын сониноор дамжуулан нийтэд зарлана.

3.2. Зар мэдээнд дараах мэдээллийг тусгана. Үүнд: Нэрээ дэвшүүлэхийг хүсэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, сонгон шалгаруулах материал хүлээн авах, хаяг, харилцах угасны дугаар, хугацаа гэх мэт. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах Томилгооны дэд хороо тухай бүрт нь мэдээлнэ.

ДӨРӨВ: СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТОМИЛГООНЫ ДЭД ХОРОО, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

4.1. Сонгон шалгаруулалтыг тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дэх Томилгооны дэд хороо /цаашид “томилгооны дэд хороо” гэх / зохион байгуулж явуулна.

4.2. Томилгооны дэд хороо сонгон шалгаруулалттай холбогдон дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах;

б/ Сонгон шалгаруулалттай холбогдох зар мэдээг нийтэд хүргэх;

в/ Нэр дэвшигчээс ирүүлсэн материалыг хүлээн авч, сонгон шалгаруулалт явуулах хуралдааны бэлтгэл ажлыг хангах;

г/ Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

д/ Сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэн үнэлэлт өгч, үнэлгээний жагсаалт гаргах;

е/ Сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан, дүгнэлт бичиж, үнэлгээний жагсаалтын хамт Хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх.

ё/ Сонгон шалгаруулалттай холбогдсон санал, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

ж/ Шаардлагатай тохиолдолд нэр дэвшигчийн талаар нэмэлт судалгаа явуулах;

з/ Сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу цэгцэлж, архивт шилжүүлэх.

ТАВ: СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОХ НЭР ДЭВШИГЧДИЙГ БҮРТГЭХ

5.1. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн нэр дэвшигчид зар мэдээнд заасан хугацаанд дараахь материалыг тухайн компанийн Томилгооны дэд хороонд ирүүлнэ. Үүнд:

а/ Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт;

б/ Өөрийнх нь тухай өөрийг нь сайн мэдэх олонд танигдсан 2 хүний ажил байдлын талаархи тодорхойлолт;

в/ Анкет;

г/ Боловсролын диплом, үнэмлэх;

д/ Иргэний үнэмлэхний хуулбар,

е/ Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

ё/ Нэр дэвшигч нь энэхүү журмын 2.4-т заасан шаардлагыг хангасан гэдгээ нотолсон баталгаа гаргах;

5.2. Нэр дэвшигчийн хувьд тухайн компанийг удирдах үйл ажиллагааны хөтөлбөр.
Үүнд:

а/ Тухайн салбарын хөгжлийн чиг хандлага, бодлогод өгсөн дүгнэлт;

б/ Компанид сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, менежментийг өөрчлөн байгуулах төсөл;

в/ Компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаархи санал /ямар шинэ арга барил, технологи нэвтрүүлэх/;

5.3. Энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.4-т заасан шаардлагыг хангаагүй, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т заасан материалыг дутуу бүрдүүлсэн нэр дэвшигчийг бүртгэхгүй.

ЗУРГАА: СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

6.1. Томилгооны дэд хороо сонгон шалгаруулалтыг дараахь байдлаар зохион байгуулна. Үүнд:

а/ Нэр дэвшигчээс ирүүлсэн материалыг судалж, тухайн төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагатай харьцуулак замаар эхний шатыг явуулна;

б/ Дараагийн шатанд нэр дэвшигчтэй ярилцлага хийнэ;

в/ Сонгон шалгаруулалтын үнэлгээг нэр дэвшигч хүн бүрээр гаргаж, дүнг нэгтгэж, дүгнэлт гарган Хувь нийлүүлэгчдийн хуралд оруулна.

НАЙМ: СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН ГАРГАХ, ТОМИЛОХ

8.1. Сонгон шалгаруулалтын дүнг Томилгооны дэд хорооны хуралдаанаар хэлэлцэн зохих дүгнэлт гаргана. Дүгнэлтийг 2 хувь үйлдэж Томилгооны дэд хорооны дарга, гишүүд гарын үсэг зурна.

8.2. Томилгооны дэд хороо нэр дэвшигч хүн бүрээр гаргасан үнэлгээ, дүгнэлтийг холбогдох бусад материалын хамт Хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

8.3. Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилохыг хориглоно.

ЕС: БУСАД ЗҮЙЛ

9.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдох оролцогчийг сонгон шалгаруулахад ус төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтан, төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс Томилгооны хороо болон Хувь нийлүүлэгчдийн хуралд аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

Төрийн өмчийн хорооны 2010 оны 3...
дугаар сарын 15..ны өдрийн 11 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ, АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ,
АЖИЛД ТОМИЛОХ, АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү журмын зорилго нь Төрийн өмчит компани болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид төрийн өмчит хуулийн этгээд гэх/-ын гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж, ажилд томилох, ажлаас чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай. Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журам, Төрийн өмчийн хорооны шийдвэрийг удирдлага болгон төрийн хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах үүрэгтэй

ХОЁР: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1 Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын албан тушаалд энэ журамд болон холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангасан хүнийг зөвхөн сонгон шалгаруулж томилно.

2.2 Гүйцэтгэх захирлын албан тушаалд ажиллах үндсэн хугацаа 4 жил, дахин нэг удаа сунгаж болох бөгөөд настын дээд хязгаар 60 байна.

2.3 Онцгой туршлага, мэдлэг, ур чадвартай гүйцэтгэх захирлыг энэ журамд зааснаас илүү хугацаагаар ажиллуулах тухай асуудлыг Төрийн өмчийн хороо салбарын яамтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

2.4 Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшигч нь дор дурдсан ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.4.1 Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр болон эдийн засаг, хууль зүйн дээд мэргэжил эзэмшсэн байх.

2.4.2 Тухайн хуулийн этгээдтэй дүйцхүйц аж ахуйн нэгжийн захирал, орлогч захирлаар 2, түүнээс дээш жил, эсхүл тэдгээрийн нэгжийн дарга, менежерээр 3-аас доошгүй жил, эсхүл төрийн албанад эдийн засаг, аж ахуйн чиглэлээр 3-аас доошгүй жил амжилттай ажилласан байх.

2.4.3 Баг бүрдүүлж ажиллах чадвар, ёс зүйн талаар хангалтгүй гэж хамт олон болон дээд байгууллагадаа дүгнүүлж буюу арга хэмжээ авагдаж байгаагүй.

2.4.4 Төрийн өмчит хуулийн этгээдийн зорилтот түвшинг ханган биелүүлэх, үйл ажиллагааг нь цаашид хөгжүүлэх хөтөлбөроө боловсруулсан, түүнийгээ хамгаалсан, биелүүлж чадаагүйн төлөө хариуцлага хүлээхэд бэлэн гэдгээ бичгээр илэрхийлсэн байх.

2.5 Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог, зорилтой холбогдуулан Төрийн өмчийн хорооноос тусгайлсан шаардлага тавьж болно.

2.6 Гүйцэтгэх захирлын ажлыг Төрийн өмчийн хорооноос тогтоосон журмын дагуу дүгнэнэ.

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

3.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигч нь дараахь баримт бичгийг бүрдүүлж Төрийн өмчийн хороонд өөрийн биеэр буюу өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, эсхүл баталгаат шуудангаар зар мэдээнд заасан хугацаанд багтаан ирүүлнэ. Үүнд:

3.1.1. Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл.

3.1.2.. Тухайн нэр дэвшигчийн биеийн байцаалт, /анкет, маягтын дагуу/.

3.1.3. Мэргэжлийн байдлыг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (Диплом, үнэмлэх гэх мэт)

3.1.4. Өөрийн харьялагдах орон нутгийн татвар, цагдаа, шүүхийн байгууллага болон банкны зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт: Үүнд:

- Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх;
- Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байгаа эсэх.

3.1.5. Тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг удирдах үйл ажиллагааны хөтөлбөр.

ДӨРӨВ: СОНГОН ШАЛГУУЛАЛТ

4.1 Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох салбарын яамтай зөвшилцөн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр тухай бүр томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.

4.2 Сонгон шалгаруулах комисс нь салбарын яам, Төрийн өмчийн хорооны төлөөлөл болон мэргэжлийн байгууллагын хүмүүсээс бүрдсэн 7-9 гишүүний бүрэлдхүүнтэй байна.

4.3 Төрийн өмчийн хорооноос томилсон комисс сонгон шалгаруулалт болохоос ажлын 21 хоногийн өмнө сонгон шалгаруулалтын тухай өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, Төрийн өмчийн хорооны веб сайтаар нийтэд зарлан мэдээлнэ.

4.4 Зар мэдээнд дараахь зүйлийг тусгасан байна:

4.4.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавих шаардлага.

4.4.2.. Сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх газар, хугацаа.

4.4.3. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт.

4.5 Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтад дор дурдсан этгээдийг оролцуулахыг хориглоно. Үүнд:

4.5.1 Санаатай үйлсэн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан,

удирдаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, эсхүл удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс өөрчлөгдсөн.

4.5.2 Хувийн өмчийн болон хувийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд ордог, олон нийт, шашны байгууллага, аливаа нэг сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэдэг хүмүүс ажлаасаа түдгэлзээгүй бол.

4.5.3 Энэ журмын Тав дахь хэсэгт заасан үндэслэлийн дагуу Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын ажлаас чөлөөлөгдж байсан этгээд.

4.6 Сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигч нь дараах эрх, үүрэгтэй байна.
Үүнд:

4.6.1 Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт Төрийн өмчийн хороонд заасан хугацаанд ирүүлэх.

4.6.2 Тухайн төрийн өмчит хуулийн этгээдийн талаар сонирхож буй мэдээллийг Төрийн өмчийн хорооны холбогдох газар, хэлтэс, веб сайтаас авах.

4.7 Төрийн өмчийн хороо дараах эрх үүрэгтэй байна: Үүнд:

4.7.1 Шаардлагатай бол нэр дэвшигчийн талаар нэмэлт мэдээлэл, тодруулга гаргуулж авах;

4.7.2 Зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэр дэвшигчийн талаар холбогдох байгууллагын саналыг албан ёсоор авах.

4.8 Төрийн өмчийн хорооны шийдвэрээр томилогдсон комисс нь гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийг ерөнхий мэдлэг, мэргэжлийн түвшин, хөтөлбөрт өгөх үнэлгээ гэсэн чиглэлээр шалгаруулж, ярилцлага хийж дүгнэлтээ Төрийн өмчийн хороонд танилцуулна.

4.9 Төрийн өмчийн хороо сонгон шалгаруулалтын комиссын дүгнэлтийн үндэслэлийг нийтэд мэдээлнэ.

4.10 Төрийн өмчийн хороо нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалтад тэнцсэн 1 хүний баримт бичгийг холбогдох салбарын яамтай зөвшилцөхөөр хүргүүлнэ. Яам уг материалыг хүлээн авсан өдөрөөс 7 хоногийн дотор саналаа Төрийн өмчийн хороонд ирүүлнэ. Дурдсан хугацаанд яам саналаа ирүүлээгүй бол зөвшилцсөнд тооцно. Хэрэв татгалзсан бол энэ тухай үндэслэл, тайлбарaa албан ёсоор бичгээр ирүүлнэ.

4.11 Төрийн өмчийн хорооны холбогдох газар, хэлтэс шалгаруулалтад тэнцсэн эхний нэг нэр дэвшигчийн холбогдох материалыг яамны санал дүгнэлтийн хамт Төрийн өмчийн хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ. Төрийн өмчийн хорооны хуралдаанаас татгалзвал сонгон шалгаруулалтын дүнгээр удаахь байр эзэлсэн хүний материалыг энэ журмын 4.8, 4.10 -д заасны дагуу шийдвэрлүүлнэ.

4.12 Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг үндэслэн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр томилж, чөлөөлнө. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлаар томилогдсон хүн Төрийн өмчийн хорооны даргатай Үр дүнгийн гэрээ байгуулна.

ТАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ҮНДЭСЛЭЛ

5.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлыг дор дурдсан үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Үүнд:

5.1.1. Төрийн өмчиг хуулийн этгээдийн зорилтот түвшинг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй.

5.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны цэвэр ашгаас төрийн өмчид төвлөрүүлэх ногдол ашгийг Сангийн яам, Төрийн өмчийн хорооноос баталсан хэмжээгээр төвлөрүүлээгүй.

5.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох бусад журам зөрчсөн.

5.1.4. Төрийн өмчиг хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн, эрх мэдлээ хэтрүүлсэн.

5.1.5. Үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүйн улмаас ноцтой осол аваар гарсан.

5.1.6. Захирлын буруу шийдвэр, үйл ажиллагааны улмаас тухайн хуулийн этгээдэд ноцтой хохирол учирсан, алдагдалд орсон.

5.1.7. Хуульд заасан бусад үндэслэл.

----- оОо -----